

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН БОГД СУМЫН ЗДТГАЗАР

БОГД СУМЫН ХӨХ ЭНГЭРТ ГҮНИЙН ӨРМИЙН ХУДАГ ГАРГАХ АЖЛЫН
ГҮЙЦЭТГЭГЧИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ТЕНДЕРТ
ҮНИЙН САНАЛ АВАХ БАРМИТ БИЧИГ

Тендер шалгаруулалтын нэр дугаар:ӨВАБОСЗДТГ/202309024

Хөх энгэрт гүн өрмийн худаг гаргах

Батлагдсан төсөв: **33000000** Гучин гурван сая/

БОГД-2023

Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

2023.10.06

[Өвөрхангайм аймгийн Богд сумын ЗДТГазар] нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос Хөх энгэрт **[Бэлчээрт гүн өрмийн худаг барих ажил]**-ыг гүйцэтгэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх ажлын зураг, техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Цахими тендер шалгаруулалт зохион байгуулах журмын дагуу тендерт оролцох хураамж 50000 \тавин мянга\ төгрөгийг tender.gov.mn системийг ашиглан онлайн хэлбэрээр төлнө.

Үнийн саналыг **[2023.10.16- ний өдрийн 15:00]**-аас өмнө **[Худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn]-д өөрийн аж ахуйн нэгжийн цахим гарын үсэг /PKI/-ээр]** хаягаар ирүүлнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан **[2023.10,16]-ны өдрийн [15:30]¹**-т нээнэ.

Дотооды давуу эрх тооцох эсэх.**Тооцно**

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

[Өвөрхангай аймаг, Богд сум 7-р баг ЗДТГ-ын 2 давхарт 5 тоот өрөө, 99064279, 99317347]

¹ Тендерийг хүлээж авах эцсийн хугацааг дууссанаас хойш 1 цагийн дотор байна.

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- 1. Эрх бүхий тендерт оролцогч**

1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
- 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт**

2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.

2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.

2.3. Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ.
- 3. Тендерийн иж бүрдэл**

3.1. Тендерт оролцогчдод өгсөн зааварчилгааны дагуу бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ:

 - (а) Үнийн санал;
 - (б) Үнэлэгдсэн үе шатны ажлын хуваарь;
 - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
 - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
 - (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
- 4. Тендерийн үнэ**

4.1. Тендерийн үнэд тодорхойлсон нийт ажил хамрах ба тендерт оролцогчийн үнэлж ирүүлсэн үе шатны ажлын хуваарьт үндэслэнэ.

4.2. Тендерт оролцогч үнийн хөнгөлөлтийг тендерт тусган санал болгож болно.

4.3. Тендерт оролцогч нь зураг болон техникийн тодорхойлолтод тодорхойлогдсон ажлыг үнэлэхдээ үе шатны ажлын хуваарьт хураангуй байдлаар өгөгдсөн бүх нэр төрөлд нэгж үнэ болон нийт үнэ санал болгоно. Тендерт оролцогч аль нэг нэр төрлийн нэгж үнэ болон нийт үнийг бөглөөгүй орхисон тохиолдолд түүнийг гүйцэтгэсний төлбөрийг захиалагч хийхгүй ба бусад нэр төрлийн үнэд багтсан гэж үзнэ.

4.4. Тендерт оролцогч нь тендер хүлээн авах эцсийн хугацаанаас 14 хоногийн өмнө хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн дагуу энэ гэрээ болон бусад үндэслэлээр гүйцэтгэгчийн төлөх ёстой бүх татвар, хураамж, бусад төлбөрийг тендерийн нийт үнэд багтаасан байна.
- 5. Үнийн саналын**

5.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30хоногийн хугацаанд хүчинтэй байна.

**хүчинтэй
байх хугацаа**

- 6. Алдааг залруулах**
- 6.1. Захиалагч шаардлагад нийцсэн тендерийн арифметик алдааг шалгаж дараах байдлаар залруулна:
- (а) тоо болон үсгээр илэрхийлэгдсэн дүн хоорондоо зөрсөн бол үсгээр илэрхийлэгдсэнийг зөв гэж үзнэ;
 - (б) үе шатны ажлын үнийн нийлбэр тендерийн маягтад заасан тендерийн нийт үнээс зөрвөл үе шатны ажлын үнийн нийлбэрийг үндэслэн тендерийн нийт үнийг залруулна;
 - (в) нэгж үнийг ажлын тоо хэмжээгээр үржүүлж гаргасан нэг мөр дэх нийт дүнд зөрүү гарвал нэгж үнийг давамгайлах гэж үзнэ. Гэхдээ захиалагчийн үзэж байгаагаар нэгж үнэд аравтын орны таслалыг андуурсан болох нь илэрхий байвал тухайн мөр дэх нийт дүнг зөв гэж үзэн холбогдох нэгж үнийг залруулна.
- 6.2. Захиалагчийн залруулсан тендерийн дүнг тендерт оролцогчийн зөвшөөрлөөр эцсийнх гэж үзнэ. Хэрэв тендерт оролцогч залруулсан дүнг хүлээн зөвшөөрөхгүй бол захиалагч түүний тендерээс татгалзана.
- 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдийн үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
- 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө утсан холбоогоор мэдэгдэж, албан бичгээр баталгаажуулна. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. **ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ**

| ТӨӨЗ-ны холбогдох заалт | Шалгуур үзүүлэлт |
|--|---|
| ТӨӨЗ 1.1 | <p>Сүүлийн 1 жилийн буюу 2022 оны санхүүгийн тайлан аудитаар баталгаажуулсан байна.</p> <ol style="list-style-type: none"> 1. Сүүлийн 1 жилийн туршлагын мэдээлэл /гэрээгээр гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/; 2. Сүүлийн нэг жилд ашигтай ажилласан байх ба борлуулалтын орлого нь төсөвт өртөгөөс багагүй байх <p>Бусад нэмэлт шаардлага:</p> <ol style="list-style-type: none"> 1. Татварын цахим тайлангийн системээс авсан татварын тодорхойлолтыг заавал ирүүлэх ба энэхүү тодорхойлолтын хүчинтэй хугацаа нь тендер нээсэн өдрийн байдлаар хүчин төгөлдөр байна. 2. Харъяа нийгмийн даатгалын газрын тодорхойлолт 3. ШШГГазрын тодорхойлолт 4. Харилцагч банкуудаас хугацаа хэтэрсэн зээлийн өргүй байх тодорхойлолт 5. Аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар наториатаар гэрчлүүлсэн байна. 6. Тусгай зөвшөөрлийн хуулбарыг наториатаар гэрчлүүлсэн байна. <p>Тоног төхөөрөмжийн жагсаалт</p> <p>Ажиллах хүн хүч, инженер техникийн ажилчдын жагсаалт ирүүлэх</p> <ol style="list-style-type: none"> 1. Тендерт оролцогч нь уг тендерт шалгарсан тохиолдолд гэрээний үнэд багтаан гүний худгийн ажлыг дуусгаж хүлээлгэн өгөх, баталгааг бичгээр гаргаж ирүүлэх. Баталгаа гаргаагүй тохиолдолд тендерээс татгалзах үндэслэл болно. 2. Тендерийн баримт бичигт заагдсан гэрээний ерөнхий болон тусгай нөхцөл, маягт зэргийг зөвшөөрч байгаа талаар мэдэгдэл ирүүлнэ. |
| ТӨӨЗ 2.1 | <p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: [Богд сумын 7-р баг ЗДТГ-ын 2 давхар 5 тоот]</p> <p>Давхар болон ерөөний дугаар: [ЗДТГ-ын 2 давхар 5 тоот]</p> <p>Огноо: [2023.10.16]</p> <p>Цаг: [15 цаг 00 минутанд]</p> |
| ТӨӨЗ 2.1 | <p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: [Богд сумын 7-р баг]</p> <p>Давхар болон ерөөний дугаар: [ЗДТГ-ын 2 давхар 5 тоот]</p> <p>Огноо: [2023.10.16]</p> <p>Цаг: [15 цаг 30 минутанд]</p> |
| ТӨӨЗ 6.2 | <p>Багцгүй болно.</p> <p>Төсөвт өртөг: 33000000/гучин гурван сая/</p> |

Дөрөв. ГҮН ӨРМИЙН ХУДАГ ГАРГАХ АЖЛЫН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

1. **Байршил:** Өвөрхангай аймгийн Богд сумын Баян-төхөм багийн Хөх энгэрт бэлчээр усжуулалтанд зориулсан гүн өрмийн худаг шинээр барьж байгуулах.

2. Ажлын тодорхойлолт:

2.1 Худгийг шинээр барихаас өмнө ба дараах үеийн гэрэл зургийг нэг цэгээс авч худгийн солбилцолыг нарийвчлан тодорхойлсон байна.

2.2 Худгийн цооног өрөмдөх, тоног төхөөрөмж суурилуулах ажилд тавих техникийн шаардлага MNS6088:2011 стандартын дагуу өрөмдлөг, шавхалт, туршилтын ажлыг явуулах, худгийн усны шахуурга, цахилгаан үүсгүүрийг сонгох, худгийн барилга барих ажлыг гүйцэтгэнэ.

2.3 Монгол улсын Хөдөө Аж Ахуйн сайд, Байгаль орчны сайд, Сангийн сайдын 2005 оны 7 дугаар сарын 15-ны өдрийн 101, 189, 194 дүгээр хамтарсан тушаалаар батлагдсан “Инженерийн хийцтэй худаг, уст цэгийг сэргээн засварлах, шинээр гаргах, санхүүжүүлэх, эзэмших, ашиглах нийтлэг журам”-ыг мөрдөнө. Үүнд:

Ажлын иж бүрдэлд цооног өрөмдөх, цооногийг цэвэрлэх, шавхалт туршилтын ажил хийх, ус шахуурлга, цахилгаан үүсгүүр суурилуулах, худгийн барилга, усан сан, мал услах онгоц талбай зэргийг барьж байгуулах ажлыг багтаана. Өрөмдмөл худгийн барилгын дотор 1,5 м³–ээс дээш багтаамжтай усан сан барьж байгуулна.

Шинээр худаг гаргах гэж байгаа бол өрөмдөхийн өмнө хайгуулын ажлаар устай эсэхийг тогтоосон акт үйлдэнэ.

Худгийн цооног өрөмдлөгийн ажлын талаархи мэдээллийг өрөмдлөгийн ажлын журналд тэмдэглэнэ.

Цооногийг засварласан болон өрөмдлөгийн ажлыг дууссаны дараа шавхалтын ажлыг заавал хийж, шавхалтын ажлын журналыг дэлгэрэнгүй үйлдэнэ.

Инженерийн хийцтэй худгийн усны шахуурга, шахуургын цахилгаан үүсгүүр, цахилгааны утас, хянах самбар, холбогч хэрэгсэл, дагалдах зүйлсийг иж бүрнээр худгийн цооног бүрт суурилуулна. Худгийн усны шахуурга дараах шаардлагын хангасан байна. Үүнд Гарал үүслийн гэрчилгээтэй, үйлдвэрлэгчийн нэр, хаяг, барааны олон улсын гэрчилгээтэй байх.

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ БОЛОН ШААРДЛАГА

| № | Үзүүлэлтүүд | Тендерт оролцогчийн санал |
|------|--|---------------------------|
| 1 | Цооног өрөмдөх, цооногийг тоноглох | |
| 1.1 | Геофизикийн судалгаа хийж, худгийн байршлыг эцэслэн тогтоох | |
| 1.2 | Цооногийн ашиглалтын ундарга: 0,8л\сек дээш байх | |
| 1.3 | Суултын яндангийн материал нь ган, ундны усанд хэрэглэхэд зөвшөөрөгдсөн хуванцар хоолой байна. | |
| 1.4 | Шүүрийн яндангийн материал нь ган, ундны усанд хэрэглэхэд зөвшөөрөгдсөн хуванцар хоолой байна. | |
| 1.5 | Ус өгөх яндангийн диаметр 32 мм-ээс багагүй, материал нь төмөр болон ундны усанд хэрэглэхэд зөвшөөрөгдсөн хуванцар хоолой ISO \ хүйтний улиралд тэсвэртэй\ | |
| 1.6 | Ус шүүх хайраг нь шигшсэн, мөлгөр хэлбэртэй, тоосонцор хорльцгүй, мөхлөгийн хэмжээ 10-15 мм-ээс томгүй байна. | |
| 1.7 | Тунгаагуурын гүн: 2м-ээс багагүй | |
| 1.8 | Худгийг шавхалт хийж цэвэрлэх хугацаа: 72 цагаас багагүй | |
| 1.9 | Усны чанарын сорилт авах шинжилгээхийлгэх | |
| 1.10 | Худгийн цооногийг түр хугацааны тагаар тоноглох | |

| | | |
|------|--|--|
| 1.11 | Цохилтот өрмөөр өрөмдсөн тохиолдолд цооногийн нийт гүнд хамгаалалтын хуванцар хоолой хийнэ. | |
| 1.12 | Худгийн гүн 50 м-ээс дээш байна. | |
| 2 | Худгийн байшин, усан сан, мал услах онгоц, талбай барих | |
| 2.1 | Худгийн байшин <ul style="list-style-type: none"> - Хэмжээ \дотор талдаа\ 3м х 3м, ханын өндөр шалнаас дээш 2м - Суурийг М250 маркийн бетон хольцоор нийт 50см-ээс багагүй өндөртэй цутгана. - Материал: Блокон өрлөг өрж, боосгоор өнгөлнө. \дээврийн төмөр 0.30мм-ээс дээш зузаантай\ - Худгийн дээврийг бага зэргийн налуу хавтгай оройтой хийнэ. - Ханын зузаан 32см - Ханыг дотор талаас нь шавардаж, цагаан өнгөөр будна. Худгийн дээр 30см х 30см хэмжээтэй нээлхийг тохируулан хийнэ. Нээлхийг худгийг засварлахад хэрэглэнэ. - Худгийн цонх нь 40см х 40см хэмжээтэй, хамгаалалтын төмөр сараалжин хаалттай байна. \Цохны байрлал нь мал услах онгоцны чанх харалдаа байрлана\ - Худгийн хаалга нь 1.5мм, 1мм-ийн давхар лст төмрөн самбартай байна. | |
| 2.2 | Мал услах онгоцонд ус өгөх хоолой нь: 60мм диатетртэй, гаднах ханаас 1м урттай гадагшилсан ган хоолойг цонхны доор гаргах | |
| 2.3 | Ундны ус авах хоолой нь: 60мм диаметртэй, ган хоолойг цонхны доор гаргах \ундны ус авахад тохиромжтой байдлаар уртыг сонгох\ | |
| 2.4 | 40мм-ийн диаметртэй цоорхойг генераторын утааг гадагшлуулах зорилгоор генераторын янданд яг тохируулан тохиромжтой байрлалд гаргана. | |
| 2.5 | Босоо суурьтай тоноглогдсон, гагнаж хийсэн, дотор талыг зэврэлтээс хамгаалсан 1.5м ³ –ээс багагүй багтаамжтай ган усан сан, дээгүүрээ модон тагтай | |
| 2.6 | Мал услах онгоц <ul style="list-style-type: none"> - Хэмжээ: 9м-ээс багагүй урттай, 400мм-ийн голчтой, 3мм зузаантай лист төмрөөр хагас цилиндр хэлбэртэй - Материал: ган хоолой буюу цутгамал төмөр бетон - Худгийн байшингаас 1-2 хэмийн налуутайгаар 1м-ийн зайд байрлуулна. - Онгоцны адагт үлдэгдэл ус юүлэх жижиг нээлхий гаргана. Нээлхийг онгоцонд ус өгөх үед эрэгдэж хаадаг байхаар хийнэ. - Усан сангаас мал услах онгоцонд ус дамжуулах хоолойг усан сангийн доод ероолын усыг бүрэн шавхахаар байрлуулж гагнана. - Онгоцыг ган яндангаар хийсэн үед ирмэгийг аюулгүй болгож засна. | |
| 2.7 | Мал услах талбай: <ul style="list-style-type: none"> - Хэмжээ: нийт уртын дагуу 4 талдаа 1м-ийн өргөнтэй, 10см зузаантай цементээр цутгасан талбай байна. - Материал: 200 маркаас доошгүй цемент хэрэглэнэ. - Услах талбай нь худгийн байшин болон мал услах онгоцтой харьцуулахад бага зэрэг налуу байдалтай хийгдэх бөгөөд үлдэгдэл ус болон асгарсан ус юүлэхэд тохиромжтой байна. | |

| | | |
|-----|---|--|
| 3 | Худгийн насос, бага оврын генератор, цахилгааны утас, хянах самбар | |
| 3.1 | Гүний насос: ISO9001 стандартын шаардлага хангасан, Монгол орны уур амьсгалын нөхцөлд иашиглах боломжтой байх | |
| 3.2 | Цахилгааны утас: 3 салаа, худагт ашиглах шаардлагыг хангасан, насосноос хянах самбар хүртэл үргэлжилсэн \залгаасгүй\, ус өргөх янданд 2 м тутамд хавчиж \туузаар ороож болохгүй\ тогтооно. | |
| 3.3 | Хянах самбар: Асаах унтраах товчлууртай, насос ажиллаж буйг \ногоон\, хүчдэл буйг \улаан\ гэрлээр асаах индикатортой, насос ажиллуулах асаагууртай. | |
| 3.4 | Бага оврын генеротот: Бензинээр ажилладаг \ISO стандартын шаардлага хангасан\ Монгол орны уур амьсгалын нөхцөлд ашиглах боломжтой байх | |
| 4 | Худгийн ажлыг дуусгаж хүлээлгэж өгөх | |
| 4.1 | Талбайг цэвэрлэх \Өрөмдлөгийн шлам, барилгын болон ахуйн хог хаягдал гэх мэт\ | |
| 4.2 | Худаг, гүнийн насос, жижиг оврын генераторыг ажиллуулах, үйлчилгээ хийх, талбайн сургалт хийх | |
| 4.3 | Худгийн паспорт бэлтгэн хүлээлгэж өгөх | |

Долоо. **ЖИШИГ МАЯГТ**
ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр], [гэрээний нэр ба дугаар]-ыг [тендерийн үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр тендерийн баримт бичгийн дагуу гүйцэтгэхээр санал болгож байна.
2. Тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш **30** хоногийн хугацаанд хүчинтэй байх ба та энэ хугацаа дуусахаас өмнө түүнийг сонгох боломжтой.
3. Гэрээг албан ёсоор байгуулах хүртэл энэхүү тендер болон түүнийг шалгарсан тохиолдолд гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл нь бидний хооронд хийгдсэн хэлцэл болно.
4. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.
5. Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгдөнө.

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

Найм. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

1. **Гүйцэтгэгч ажил гүйцэтгэх**
 - 1.1. Гүйцэтгэгч гэрээний тусгай нөхцөлд заасан ажлыг техникийн тодорхойлолт болон зургийн дагуу хийж гүйцэтгэнэ.
2. **Төслийн менежерийн шийдвэр**
 - 2.1. Гэрээнд тусгайлан заагаагүй бол гэрээтэй холбогдсон аливаа асуудлыг захиалагчийг төлөөлөн төслийн менежер шийдвэрлэнэ.
3. **Ажил дуусгаахаар төлөвлөсөн өдөр ажил дууссан байх**
 - 3.1. Гүйцэтгэгч ажлыг гэрээний тусгай нөхцөлд заасан өдөр эхлүүлж, өөрийн гаргасан ажлын хөтөлбөр болон төслийн менежерийн баталсан тодотгосон ажлын хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэн, ажил дуусгаахаар төлөвлөсөн өдөр дуусгана.
4. **Аюулгүй байдал**
 - 4.1. Гүйцэтгэгч ажлын талбай дээрх бүх үйл ажиллагааны аюулгүй ажиллагааг хангаж ажиллана.
 - 4.2. Барьж байгаа барилга, байгууламжаа байгалийн болзошгүй гамшиг, гэнэтийн аюулаас хамгаалах бүх талын арга хэмжээг авч, өөрийн нь ажилтай холбогдуулж барилгын болон байгаль орчин, эрүүл ахуй, гал түймрийн хяналтын албанаас гаргасан хууль ёсны шаардлага, дүгнэлтийг хүлээн авч биелүүлнэ.
5. **Зааварчилгаа**
 - 5.1. Төслийн менежерийн гаргах аливаа зааварчилгаа нь Монгол улсын хууль, тогтоомжид нийцсэн байх бөгөөд түүнийг гүйцэтгэгч биелүүлэх үүрэгтэй
6. **Маргааныг шийдвэрлэх**
 - 6.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.
7. **Ажлын хөтөлбөр**

Б. ХУГАЦААНЫ БОЛОН ЧАНАРЫН ХЯНАЛТ

 - 7.1. Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэхэд шаардлагатай бүх үйл ажиллагааны ерөнхий аргачлал, зохион байгуулалт, дэс дараалал, ажил гүйцэтгэх хугацаа болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан ажлын хөтөлбөрийг боловсруулж, гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд төслийн менежерт хүргүүлж батлуулна.
 - 7.2. Ажлын хөтөлбөрийг төслийн менежер батлах нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Гүйцэтгэгч нь ажлын хөтөлбөрийг хянан засварлаад төслийн менежерт хэдийд ч дахин хүргүүлж болно. Хянан засварласан ажлын хөтөлбөрт өөрчлөлтийг тусгана.
8. **Зөрчил, гологдол илрүүлэх**
 - 8.1. Төслийн менежер гүйцэтгэгчийн ажлыг шалгаж, илэрсэн зөрчил, гологдлын талаар түүнд мэдэгдэнэ. Энэхүү шалгалт нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Төслийн менежер зөрчил, гологдол байж болзошгүй гэж үзсэн аливаа ажилд зөрчил, гологдол хайх, уг ажлын далд хэсгийг нээж шалгалт, туршилт явуулах талаар зааварчилгааг гүйцэтгэгчид өгөх эрхтэй.
9. **Зөрчил, гологдол арилгах**
 - 9.1. Төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан чанарын баталгаат хугацаа² дуусахаас өмнө зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдлийг гүйцэтгэгчид өгнө. Чанарын баталгаат хугацааг зөрчил, гологдлыг арилгаж дуусах хүртэл сунгана.

² Чанарын баталгаат хугацааг тогтоохдоо Иргэний хууль болон Барилгын тухай хуулийг баримтална.

- 9.2. Зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдэл өгсөн тухай бүр гүйцэтгэгч уг зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж өөрийн зардлаар арилгана.
10. **Зөрчил, гологдол арилгахгүй байх**
- 10.1. Хэрэв гүйцэтгэгч зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж арилгаагүй бол төслийн менежер зөрчил, гологдол арилгахад шаардагдах зардлыг тооцож гүйцэтгэгчээс гаргуулна.

В. ЗАРДЛЫН ХЯНАЛТ

11. **Үе шатны ажлын хуваарь**
- 11.1. Төслийн менежерийн шаардсаны дагуу гүйцэтгэгч үе шатны ажлын тодотгосон хуваарийг 14 хоногийн дотор бэлтгэж ирүүлнэ. Үе шатны ажлын хуваарьт тусгагдсан үйл ажиллагаа нь ажлын хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаатай нийцсэн байна.
- 11.2. Ажлын талбай дахь материалын төлбөрийг тусад нь хийх бол гүйцэтгэгч ажлын талбайд нийлүүлсэн материалын тооцоог үе шатны ажлын хуваариас тусад нь гаргаж ирүүлнэ.
12. **Үе шатны ажлын хуваарийг өөрчлөх**
- 12.1. Гүйцэтгэгчийн шийдвэрээр ажлын арга барил, эсхүл ажлын хөтөлбөрт гарсан өөрчлөлтийг тусгах зорилгоор гүйцэтгэгч үе шатны ажлын хуваарьт нэмэлт өөрчлөлт хийнэ. Өөрчлөлт хийхдээ үе шатны ажлын хуваарь дахь үнийг өөрчлөхгүй.
13. **Алданги**
- 13.1. Гүйцэтгэгч нь ажил дуусгахаар төлөвлөсөн өдрөөс хугацаа хоцорсон хоног тутамд гэрээний тусгай нөхцөлд заасан хувь хэмжээгээр алданги³ төлнө. Алдангийн нийт дүн гэрээний тусгай нөхцөлд заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. Захиалагч нь алдангийг гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс суутган авч болно. Алданги төлсөн нь гүйцэтгэгчийн хүлээсэн үүрэг хариуцлагыг хөндөхгүй.

Г. ГЭРЭЭГ ДУУСГАХ

14. **Ажил дуусгах**
- 14.1. Гүйцэтгэгч нь ажил дууссан тухай мэдэгдэл гаргах хүсэлтийг төслийн менежер тавих бөгөөд төслийн менежер ажил дууссан гэж үзвэл уг мэдэгдлийг гаргана. Гүйцэтгэгч гадна тохижилтын ажлыг бүрэн дуусгаж, ажлын явцад гудамж, зам, талбай сэтэлж, мод, цэцэрлэгжүүлэлтийг түр зайлуулсан бол эдгээрийг бүрэн хэмжээгээр сэргээсэн байна.
15. **Хүлээж авах**
- 15.1. Төслийн менежер ажил дууссан тухай мэдэгдэл гаргаснаас хойш захиалагч долоо хоногийн дотор ажлын талбай болон ажлыг хүлээж авна.
16. **Эцсийн тооцоо**
- 16.1. Гүйцэтгэгч гэрээний дагуу төлөгдөх ёстой гэж үзэж буй нийт төлбөрийн нарийвчилсан тооцоог гаргаж, чанарын баталгаат хугацаа дуусахаас өмнө төслийн менежер хүргүүлнэ. Төслийн менежер зөрчил, гологдол арилгасан тухай мэдэгдэл гаргаж, хэрэв гүйцэтгэгчийн ирүүлсэн тооцоо бүрэн гүйцэд, үнэн зөв бол уг тооцоог хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор гүйцэтгэгчид төлөх эцсийн төлбөрийг тодорхойлно. Хэрэв тооцоо буруу байвал шаардлагатай залруулга, нэмэлт өөрчлөлтийн талаарх тайлбарыг 14 хоногийн дотор гаргаж гүйцэтгэгчид хүргүүлнэ. Хэрэв засвар хийж дахин ирүүлсэн эцсийн тооцоо нь шаардлага хангаагүй бол төслийн менежер гүйцэтгэгчид төлөх дүнг шийдвэрлэж төлбөрийн мэдэгдэл гаргана.

³ Алдангийг ихэвчлэн хоногт 0.05-0.10 хувиар тогтоох бөгөөд нийт дүн нь гэрээний үнийн 5-10%-иас хэтрэх ёсгүй.

- 17. Ашиглалт, засвар, үйлчилгээний гарын авлага**
- 17.1. Гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийн зураг, далдлагдсан ажил, инженерийн шугам сүлжээ, технологийн тоног төхөөрөмжийг туршиж тохируулсан акт болон захиалагч шаардсан бол ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд хүлээлгэн өгнө.
- 17.2. Хэрэв гүйцэтгэгч 22.1-д заасан материалыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд ирүүлээгүй, эсхүл шаардлага хангаагүйн улмаас тэдгээрийг төслийн менежер батлаагүй бол гүйцэтгэгчид төлөх ёстой төлбөрөөс төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан үнийн дүнг суутгана.
- 18. Гэрээг цуцлах**
- 18.1. Захиалагч, эсхүл гүйцэтгэгч нөгөө тал нь гэрээг ноцтой зөрчсөн гэж үзвэл гэрээг цуцлах эрхтэй.
- 18.2. Дор дурдсан нөхцөлүүдийг гэрээний ноцтой зөрчил гэж үзэх бөгөөд эдгээрээр хязгаарлагдахгүй:
- (а) ажлын хөтөлбөрт ажил зогсоох тухай заагаагүй, түүнчлэн ажил зогсоох тухай шийдвэрийг төслийн менежер батлаагүй байхад гүйцэтгэгч ажлыг 28 буюу түүнээс дээш хоногийн хугацаагаар зогсоосон;
 - (б) төслийн менежер ажлын явцыг зогсоох зааварчилгааг гүйцэтгэгчид өгсөн бөгөөд уг шийдвэрээ 28 хоногийн дотор цуцлаагүй;
 - (в) захиалагч, эсхүл гүйцэтгэгч дампуурсан, эсхүл өөрчлөн байгуулагдах, нэгдэхээс бусад зорилгоор татан буугдсан;
 - (г) тодорхой зөрчил, гологдлыг арилгаж чадаагүй нь гэрээний ноцтой зөрчил болохыг төслийн менежер гүйцэтгэгчид мэдэгдсэн бөгөөд гүйцэтгэгч нь уг зөрчил, гологдлыг заасан хугацаанд нь багтаан арилгаж чадаагүй;
 - (д) гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийг гэрээний тусгай нөхцөлд заасан алдангийн дээд хэмжээ төлөх хугацаагаар хоцроосон.
- 18.3. Гэрээг цуцалсан тохиолдолд гүйцэтгэгч ажлыг даруй зогсоож, ажлын талбайн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангаж, түүнийг аль болох түргэн хугацаанд чөлөөлнө.
- 19. Гэрээг цуцалсан үед хийх төлбөр**
- 19.1. Гүйцэтгэгч гэрээг ноцтой зөрчсөний улмаас гэрээ цуцлагдсан бол төслийн менежер гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээг нотолсон мэдэгдэл гаргана. Ингэхдээ мэдэгдэл олгосон өдөр хүртэл дуусаагүй ажлын гэрээний тусгай нөхцөлд заасан хэмжээг дээрх үнэлгээнээс хасна. Нэмэлт алданги гүйцэтгэгчид ногдуулахгүй.
- 19.2. Гэрээг захиалагчийн шаардлагаар, эсхүл гэрээг захиалагч ноцтой зөрчсөний улмаас цуцалсан бол гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээ, тоног төхөөрөмжийг ажлын талбайгаас гаргах бодит зардал, ажлын зорилгоор хөлслөн ажиллуулсан гүйцэтгэгчийн ажилтнуудыг буцаахтай холбогдсон зардал, түүнчлэн ажлыг хадгалах, хамгаалахтай холбогдсон зардал зэрэг гүйцэтгэгчийн зардлыг төслийн менежер хянаж мэдэгдэл гаргана.

20. Гүйцэтгэлээс чөлөөлөх

20.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдлын улмаас гэрээг гүйцэтгэх боломжгүй болсон бол төслийн менежер үүнийг гэрчилнэ. Гүйцэтгэгч нь энэхүү мэдэгдлийг хүлээн авсны дараа ажлын талбайн бүрэн бүтэн байдлыг хангаж, ажлыг аль болох богино хугацаанд зогсооно. Захиалагч уг мэдэгдэл гарахаас өмнө хийгдсэн ажил болон түүний дараа захиалгаар гүйцэтгэсэн ажлын хөлсийг гүйцэтгэгчид төлнө.

Ес. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ⁴

| | |
|----------|---|
| ГЕН 2.1 | Гэрээний нэр болон бүртгэлийн дугаар: <i>[Тендерийн урилгад заасан нэр болон дугаар]</i> |
| ГЕН 2.1 | Ажил нь <i>[товч тодорхойлолт, түүний дотор төслийн хүрээнд бусад гэрээтэй холбогдох байдал]</i> -аас бүрдэнэ. Ажлын талбай нь <i>[байршил]</i> -д байрших ба зураг №...-д зааснаар тодорхойлогдсон болно. |
| ГЕН 3.1 | Төслийн менежер нь <i>[томилогдсон этгээдийн нэр, хаяг]</i> |
| ГЕН 4.1 | Ажил эхлэх өдөр <i>[огноо]</i> Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр <i>[огноо]</i> ⁵ |
| ГЕН 7.1 | Гүйцэтгэгч гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш <i>[тоо]</i> хоногийн дотор тодотгосон ажлын хөтөлбөрийг гаргана. |
| ГЕН 9.1 | Чанарын баталгаат хугацаа <i>[тоо]</i> хоног байна. |
| ГЕН 13.1 | Алданги ногдуулах хэмжээ хоногт гэрээний үнийн <i>[хувь]</i> байна. ⁶ Нийт ажилд ногдуулах алдангийн дээд хэмжээ нь гэрээний үнийн <i>[хувь]</i> байна. |
| ГЕН 17.1 | Ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг <i>[огноо]</i> -ны дотор гаргаж өгнө. Гүйцэтгэлийн зургийг <i>[огноо]</i> -ны дотор гаргаж өгнө. Гүйцэтгэлийн зургийг, эсхүл ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг хугацаанд нь гаргаж өгөөгүй тохиолдолд суутгах төлбөрийн хэмжээ <i>[мөнгөн дүн]</i> байна. |
| ГЕН 19.1 | Ажил дуусгахад захиалагчаас гарах нэмэлт зардлыг дуусаагүй ажлын <i>[хувь]</i> -иартооцно. |

⁴ Захиалагч тендерийн баримт бичгийг тараахаас өмнө гэрээний тусгай нөхцөлийг бүрэн бөглөсөн байна. Захиалагчийн гаргах хуваарь, тайланг гэрээний тусгай нөхцөлд хавсаргана.

⁵ Ажлыг хэсэгчлэн дуусгахаар төлөвлөсөн бол эдгээр хугацааг жагсаана.

⁶ Ажлыг хэсэг хэсгээр дуусгах болон хэсэг бүрт алданги хэрэглэх бол энд тусгана.

ГЭРЭЭНИЙ МАЯГТ

ЗАХИАЛАГЧ

ГҮЙЦЭТГЭГЧ

_____ (Тамга, тэмдэг)

_____ (Тамга, тэмдэг)

_____ (Гарын үсэг)

_____ (Гарын үсэг)

_____ (Албан тушаал)

_____ (Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас [захиалагчийн нэр] (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас [гүйцэтгэгчийн хот, улс, гүйцэтгэгчийн нэр] (цаашид “гүйцэтгэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны ____ сарын ____-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний хууль, Барилгын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу инженерийн хийцтэй барилга байгууламж барих, засварын ажил гүйцэтгэх, тоног төхөөрөмж суурилуулахтай холбогдон захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

2. Захиалагч нь [гэрээний нэр, дугаар]-г (цаашид “ажил” гэх) [гэрээний үнийг тоогоор болон үсгээр] (цаашид “гэрээний үнэ” гэх) гүйцэтгэхээр ирүүлсэн гүйцэтгэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ буюу ажлын нийт төсөвт өртөг нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

3. Гэрээний нийт дүн: _____ төгрөг. Үүнээс: /Аль тохирохыг нь бөглөнө, бусдыг нь устгана/

Улсын төсвөөс: 20.... онд: _____ төгрөг; 20.... онд: _____ төгрөг;

Орон нутгийн төсвөөс: 20.... онд: _____ төгрөг; 20.... онд: _____ төгрөг;

Өөрийн хөрөнгө: 20.... онд: _____ төгрөг; 20.... онд: _____ төгрөг.

4. Гүйцэтгэгч нь _____ байршилтай _____ хүчин чадал бүхий _____ ам.метр талбай/ _____ шоо метр эзлэхүүн/-тай, _____ суурь, _____ хана, _____

хучилттай, _____ давхар _____ барилга угсралт /барилгын засвар, тоног төхөөрөмж суурилуулах/-ын ажлыг _____ инженерийн шугам сүлжээ /дулаан, цахилгаан, цэвэр, бохир усан хангамж/, _____ туслах барилга /бусад ажил/-ын хамт _____ оны _____ дугаар сарын ____-ны өдөр эхэлж, _____ оны _____ дугаар сарын ____-ны өдөр ашиглалтад оруулна.

5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

- 5.1. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
- 5.2. Бусад шаардлагатай баримт бичиг ;
- 5.3. Үнийн санал
- 5.4. Гэрээний тусгай нөхцөл;
- 5.5. Гэрээний ерөнхий нөхцөл;
- 5.6. Техникийн тодорхойлолт;
- 5.7. Зураг;

- 5.8. Гүйцэтгэгчийн ирүүлсэн үе шатны ажлын хуваарь :
- 5.9. Санхүүжилтийн хуваарь;
- 5.10. Ажил гүйцэтгэх хуваарь.

Гэрээ нь энд дурдсан ажлыг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний бичиг баримтууд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Захиалагч, гүйцэтгэгч нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг хүлээнэ.

7. Гүйцэтгэгч нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил, гологдол арилгах үүрэг хүлээнэ.

8. Захиалагч нь гэрээний дагуу гүйцэтгэгчийн хийх ажил болон зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг, хүлээнэ.

9. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг] _____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг] _____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]